

'Автозам, гүүрийн барилга, засварын машин механизмын машин цагийн жишиг үнэ тооцох дүрмийн төсөл, машин цагийн тарифыг шинэчлэн боловсруулсан тухай танилцуулга

Монгол улсын Дэд бүтцийн яаманд барилга, авто зам, эрчим хүч, усны барилгын байгууллагууд харъяалагдаж байсан үе буюу 2002 онд барилга, авто замын байгууллагуудын машин-цагийн үнийг зохиох аргачлал, барилга, замын машины засвар, үйлчилгээнд хэрэглэгдэх сэлбэг зарцуулалтын норм, шатахуун зарцуулалтын норм, машин-цагийн жишиг үнийн тарифыг батлан мөрдүүлж байсан бөгөөд энэхүү норм, тарифыг 2010 он хүртэл шинэчлэхгүйгээр мөрдөж байсан юм.

Замын байгууллагууд 2010 онд машин-цагийн үнийг шинэчлэхдээ МУ-ын Дэд бүтцийн яамны сайдын 2002 оны 316 дугаар тушаалаар баталсан аргачлал, сэлбэг зарцуулалтын нормыг баримтлан жишиг үнийн тарифаа шинэчилсэн бөгөөд тухайн үедээ дэд бүтцийн бусад салбаруудаас анх удаа түрүүлж машин-цагийн үнэ, тарифаа шинэчлэн эдийн засгийн инфляцийн нөлөөллийг үнэ, тарифдаа тооцон тусгуулж байсан бөгөөд үүнээс хойш өнөөг хүртэл 5 жилийн хугацаанд үнэ тарифдаа өөрчлөлт хийлгүй явж ирсэн байна.

Энэ хугацаанд манай улсын эдийн засгийн өсөлт саарч инфляци нэмэгдсэний дээр шатахуун, сэлбэг хэрэгсэл, машин механизмын үнэ өсч нийгмийн дундаж зардлын өсөлтийг замын ажлын төсвийн суурь нормд тусгах шаардлага гарсаар байна.

Тус судалгааны төв нь зах зээл хөгжсөн бусад орнуудад тухайлбал ОХУ, АНУ-д замын машин, механизмын машин-цагийн үнийг тооцож буй аргачлал, арга зүйг судлан судалгааны нилээд материал цуглуулж өөрийн орны онцлогтой уялдуулан харьцуулсан судалгаа хийсэн бөгөөд манай улсын авто замын салбарын үйлдвэрлэлийн зохион байгуулалт, технологи, замын ажлын норм, дүрэм нь ОХУ-ын зам барилгын байгууллагуудтай зохих хэмжээгэр ижил төстэй байгаа байдал, түүнчилэн замын салбарт сүүлийн 10-аад жилд зах зээл хөгжсөн орнуудад тухайлбал: АНУ, Европын холбооны улсуудад мөрдөгдөж байгаа AASHTO, ASTM, EN –ын норм, стандартуудыг өргөн хэмжээгээр мөрдөх болсон, тэрчилэн МУ-ын Засгийн газраас ойрын ирээдүйд EN –ын норм, стандартуудыг нэвтрүүлэхээр шийдвэрлэснийг үндэслэн ОХУ-ын замын байгууллагуудад одоо мөрдөж буй **ГОССТРОЙ-оос 2001 онд НЗ – 189/10** тоот тушаалаар баталсан “**Методические указания по разработке сметных норм и расценок на эксплуатацию строительных машин и автотранспортных средств**” аргачлал, АНУ-ын авто зам, барилгын салбарт 2003 оноос мөрдөж буй “**Construction equipment management for engineers, estimators, and owners**” – аргачлалыг тус тус баримтлан 'Автозам, гүүрийн барилга, засварын машин механизмын машин

цагийн жишиг үнэ тооцох аргачлал”-ын төслийг боловсруулж энэ аргачлалын төслийн дагуу замын машин, механизмийн нэг машин-цагийн жишиг үнийн төслийг боловсруулав.

Аргачлалын төсөлд 1 машин-цагийн үнийг тооцохдоо:

- Нэг машин цагт ноогдох элэгдэл хорогдлын шимтгэл
- Нэг машин цагт ноогдох техник үйлчилгээ оношлогоо бүх төрлийн засварын зардал
- Нэг машин цагт ноогдох түргэн элэгдэх, сэлбэг хэрэгслийн зардал
- Нэг машин цагт ноогдох механизмын цалин
- Нэг машин цагт ноогдох эрчим хүч, шатахууны зардал
- Нэг машин цагт ноогдох тосолгооны материалын зардал
- Нэг машин цагт ноогдох ажлын (гидрийн) шингэний зардал
- Нэг машин цагт ноогдох нүүлгэн шилжүүлэх зардал
- Нэг машин цагт ноогдох эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл
- Нэг машин цагт ноогдох хээрийн нэмэгдэл
- Нэг машин цагт ноогдох даатгал
- Нэг машин цагт ноогдох албан татвар
- Замын удирдлагын бусад шууд зардал
- Замын удирдлагын нэмэгдэл зардал

Замын удирдлагын төлөвлөгөөт хуримтлал (ашиг) зэрэг зардлыг оруулж тооцсон болно.

Шинэ аргачлалын төслөөр замын машин механизмын нэг машин цагийн үнийг тооцохдоо хуучин мөрдөж байсан 154 машин, механизмийн машин-цагийн үнийг шинэчилж тооцсоны зэрэгцээ шинээр 86 машин, механизмийг нэмж нийт 244 машин, механизмийн нэг машин-цагийн үнийн төслийг тооцов.

Тооцооноос харахад шинэ аргачлалаар тооцсон замын машин механизмын нэг машин цагийн үнийн төсөл нь Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2010 оны 275 дугаар тушаалаар батлагдсан “Замын машин механизмын ашиглалтын

цагийн жишиг үнэ”-тэй харьцуулахад 1.0 -2.0 дахин өссөн үзүүлэлт харагдаж байна.

Тэрчилэн замын машин механизмын нэг машин - цагийн үнийн төслийг барилгын салбарт 2012 оноос мөрдөгдөж байгаа барилгын машин ашиглалтын нэг машин цагийн үнэтэй харьцуулж үзэхэд 10.0 -60.0 %-иар өсч байна.

Энэхүү танилцуулгад дараах материалыг хавсаргав.

Үүнд:

1. 'Авто зам, гүүрийн барилга, засварын машин механизмын машин цагийн жишиг үнэ тооцох аргачлалын төсөл-1 ширхэг, бүгд 24 хуудас
2. 'Авто зам, гүүрийн барилга, засварын машин механизмын нэг машин - цагийн жишиг үнийг тодорхойлсон жишээ -1 ширхэг, бүгд 9 хуудас
3. 'Авто зам, гүүрийн барилга, засварын машин механизмын нэг машин - цагийн 2016 оны жишиг үнийн төсөл / 244 машин механизмаар / - бүгд 7 хуудас
4. 'Автозам, гүүрийн барилга, засварын машин механизмын машин цагийн жишиг үнэ тооцох аргачлалын төсөл-1 ширхэг, бүгд 24 хуудас
5. 'Автозам, гүүрийн барилга, засварын машин механизмын 2016 оны нэг машин - цагийн жишиг үнийн төслийг барилгын машин ашиглалтын нэг машин - цагийн жишиг үнэтэй харьцуулсан судалгаа- бүгд 7 хуудас

2016 оны 2 дугаар сар 2 –ны өдөр